



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар A/338

Улаанбаатар хот

Г Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн
батлах тухай

Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан хичээлийн жилийн бүтцийг 2023/2024 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд мөрдсүгэй.
3. Хичээлийн жилийн бүтцэд нийцүүлэн сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан 2023 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор батлуулахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (М.Итгэл)-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн захиргааны байгууллагын дарга нарт, хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангаж, хяналт тавьж, ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т тус тус даалгасугай.
5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай" 2020 оны А/244 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН



14231 1332



Ерөнхий боловсролын сургуулийн хичээгийн жилийн бүтэц

Тайлбар:

1. Нэг, хоёр, гуравдугаар улирлын амралт Даваа гарарт эхэлж, Баасан гарарт дуусна. Үнтэй холбоотойгоор нэгдүгээр улирлын хичээллэх хугацаан дээр хоног нэмэгдэх, хасгдах тохиолдолд хичээлийн жилийн нийт хугацааг баримтлан 4 дүгээр улирлын үргэлжлэх хугацаанд зохицуулалт хийнэ.
 2. Хичээлийн жилийн 4 дүгээр улирлын сүүлийн долдоо хоногт 4-12 дугаар ангид Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулна.

Тэмдэглэгээ: А-Амрагт